



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

№39 /483/

2023.03.03

Цаг үе, үйл явдал

ЭНЭ ЖИЛ ОЮУТАН ЦЭРЭГ СУРГАЛТАД 200 ОРЧИМ ОЮУТАН ЗАЛУУСЫГ ХАМРУУЛНА



сургалтын явцад 1,5 сая төгрөг зарцуулдаг. Оюутан цэрэг сургалтад жилд 1000 орчим оюутан залуусыг хамруулж байсан бол улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор өнгөрсөн жилээс эхлээд уг сургалтад төсөвлөгдөх мөнгө ихээхэн танагдсан. БХЯ-ны хувьд оюутан цэрэг сургалтад хамруулах оюутнуудын тоог аль болох ахиу байлгахад ямар нэг асуудал байхгүй хэдий ч батлагдсан төсөв хязгаарлагдмал байгаа учир энэ жилийн хувьд зөвхөн нийслэлийн их, дээд сургуулиудаас 200 орчим оюутныг хамруулах төлөвтэй байна” гэдгийг онцолсон юм.

Түүнчлэн Боловсролын ерөнхий газрын цахим шилжилт, нэгдсэн статистикийн газрын дарга Н.Мөнхсанчир “Одоогийн байдлаар Монгол Улсад боловсролын 69 дээд байгууллага тогтмол үйл ажиллагаа явуулж байгаагийн 64 нь Улаанбаатар хотод байршилтай байна. Энэ жилийн хувьд эдгээр их, дээд сургуулиас оюутнуудын сурлагын голч дүн, холбогдох мэдээллүүдийг энэ оны 2 дугаар

сарын 20-ны өдрийг хүртэл хүлээн авч оюутан цэргийн сургалтад хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан оюутнуудын мэдээллийг E-Mongolia системд оруулж байна. Бидэнд ирүүлсэн мэдээллээр их, дээд сургуульд суралцаж буй 22 мянга гаруй оюутан байгаагаас 8 мянга гаруйг эрэгтэй, 14 мянга гаруйг эмэгтэй оюутнууд эзэлж байна. Үүний 4887 нь 2.8-аас дээш голчтой буюу шалгуур үзүүлэлтийг хангасан гэсэн мэдээлэл байна” гэлээ.

Онцлоход “Оюутан-цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлд хамрагдах хүсэлтэй оюутнууд дараах шаардлагыг хангасан байхыг анхаарна уу!

-Нийслэл Улаанбаатар хот дахь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 1-р дамжааны оюутан байх;

-Сурлагын голч дүн 2,8-аас дээш байх;

-2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн байх;

-Эрүүл мэндийн даатгал төлөгдсөн байх зэрэг болно.

Ө.НАСАНТОГТОХ

2023 оны “Оюутан-цэрэг” сургалтын бүртгэлтэй холбоотойгоор өнөөдөр БХЯ, ЦХХХЯ, БШУЯ-ны мэргэжилтнүүд хэвлэлийн бага хурлыг ЦДБЭЧ-ын “Соёмбо” танхимд зохион байгууллаа.

2023 оны “Оюутан-цэрэг”-ийн бүртгэлийг “E-Mongolia” систем гар утасны аппалейкшн, веб портал сайт, төрийн үйлчилгээний оператороор дамжуулан 3 дугаар

сарын 6-10-ны өдрүүдэд зохион байгуулна. Түүнчлэн 14-ний өдрөөс шалгуур хангасан оюутнууд харьяа дүүргийнхээ Цэргийн штабт өөрийн биеэр очиж бүртгэлээ баталгаажуулан 20-ны өдрөөс эрүүл мэндийн үзлэгт хамрагдах юм.

БХЯ-ны СБТГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа С.Рагчаадорж хэвлэлийн бага хурлын үеэр “Тус хөтөлбөрт хамрагдаж буй оюутанд



ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД “ТАЛХ ЧИХЭР”-ТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



болон төлөвшиж буй залууст цэргийн жинхэнэ алба нэр төртэй хааж байгаад Баянгол дүүргийн удирдлага, Цэргийн штабын хамт олон талархаж байгаагаа илэрхийлэв. Энэ үеэр Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байлдагч Ө.Зоригтбаатар дугуйн спортын “Дэд мастер”-ын тэмдгийг энгэрт нь зүүж, хугацаат албаны дайчдад дархлаа дэмжих бүтээгдэхүүн, гарын бэлэг гардуулсан юм.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг угтан Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдыг “Талх чихэр” ХК-ны үйл ажиллагаатай танилцууллаа.

Энэ нь Баянгол дүүргийн хэмжээнд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, цэргийн жинхэнэ алба хааж буй дайчдын нөхцөл байдалтай танилцах, хүүхэд, залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой юм.

1984 онд Талх чихрийн комбинат нэртэйгээр үйл ажиллагаагаа анх эхлүүлж, 1999 онд хувьчлагдан “Талх чихэр” нэртэй болсон тус ХК нь өдгөө олон нэр төрлийн талх, нарийн боов, бялуу, жигнэмэг үйлдвэрлэдэг томоохон баялаг бүтээгчдийн нэг болжээ. Хугацаат албаны дайчид “Талх чихэр” ХК-ны үйлдвэртэй танилцан шинэхэн бүтээгдэхүүний

дээжээс амталгаа хийж, ажлын байрны сургалт сурталчилгаатай танилцлаа. Хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн брэнд бүтээгдэхүүн хэрхэн бий болдог, орчин үед ажлын байранд ямар шаардлага тавигддаг, хэрхэн сурч хөгждөг зэрэг чухал мэдээллээр хангагдсан нь ирээдүйн зорилгыг нь илүү тодорхой болгож өгсөн хэмээн хугацаат албаны дайчид онцолсон юм.

Үүний дараа хугацаат цэргийн алба хаагчдыг тэдний ар гэртэй уулзуулсан юм. Энэхүү уулзалтад дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга Б.Мөнгөнхуяг, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Мөнхзаяа, Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч хурандаа Э.Мөнх-Оргил нар оролцлоо. Монгол Улсын иргэний хувьд Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн, эх орноо батлан хамгаалах ариун үйлсэд зүтгэхэд хэзээд бэлэн, эр цэрэг, эх орны хүү



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,531	3,534
EUR 🇪🇺	3,760	3,777
CNY 🇨🇳	511.50	513
RUB 🇷🇺	45.90	46.30
JPY 🇯🇵	26.20	26.45
KRW 🇰🇷	2.71	2.73

ЗУРХАЙ



2023.03.03 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР
НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН БИЧ ӨДӨР
Үс засуулбал:
Эрхтэн хурц болно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.30-18.38
Барилдлага:
Үл тохирох
ШҮТЭН БАРИЛДАГА:
Өтлөх үхэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 680,356,335

Эдгэрсэн

Нийт: 653,151,730

Нас барсан

Нийт: 6,802,881

Цахим шууданд

ЦАСНЫ БАЯРААР...



Ажилтан, алба хаагчдын албандаа хандах хандлагыг дээшлүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар монгол үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн "Цэвэр агаар-эрүүл мэнд" сэдэвт цасны баярыг зохион байгууллаа.

Тэмцээний хүрээнд бие бүрэлдэхүүн гурван багт хуваагдаж дуу хуурын мэндчилгээ, сээр цохих, сурын харваа, мөсний шагайн харваа, асуулт хариулт, олс таталтын тэмцээн болон цас мөсний үзүүлбэр зэрэг монгол

үндэсний тоглоом наадгайгаар өрсөлдсөний зэрэгцээ оюун ухаан, танин мэдэхүйн мэдлэгээ сорьцгоолоо.

Мөн энэ үеэр монгол үндэсний дээл хувцсаа ёс заншлын дагуу, бүрэн гүйцэт, зөв цэмцгэр өмссөн ажилтан, алба хаагчийг шалгаруулахад Б.Болор-Эрдэнэ, Г.Оюунчимэг нар тус тус тэргүүлсэн бол тэмцээний нийлбэр дүнгээр хошууч Б.Батхүү ахлагчтай "Эрүүл агаар, цас, мөс" баг шилдгээр тодорч бусад нөхдөө манлайллаа.

Ахлах дэслэгч Д.НИНЖБАДГАР

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн удирдлага, офицер, ахлагчдын төлөөллүүдээс бүрдсэн 25 цэргийн алба хаагчид ОБЕГ-ын дэргэдэх Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв болон Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн зохион байгуулсан сургалтад хамрагдлаа.

Энэ үеэр ОБЕГ-ын дэргэдэх Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн дарга хурандаа А.Алтанбагана болон орлогч дарга дэд хурандаа М.Мөнхзул нар нийт бие бүрэлдэхүүнд ОБЕГ-ын түүхэн замнал, техник тоног төхөөрөмж,

бүтэц зохион байгуулалтын талаар танилцуулсан бол Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн орлогч дарга дэд хурандаа М.Цогтбаяр утаат орчин болон газар хөдлөлтийн үед амьд гарах арга ухаан, тус төвийн ахлах багш ахлах дэслэгч А.Золжаргал гашгийн аюулаас урьдчилан сэргийлэх, галын хор болон гамшгийн үед хэрэглэх тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллах талаар тус тус мэдээлэл хийж холбогдох заавар зааварчилгааг өгсөн юм.

Ахлах дэслэгч Д.НИНЖБАДГАР
Гэрэл зураг-нэг агшин



ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛИЙН "ЭРДЭМ СУДЛАЛ-2023" МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ХҮРЭЛЦЭН ИРЭХИЙГ УРЬЖ БАЙНА

СЭДЭВ: "ЭРДЭМ СУДЛАЛ-2023"

Зорилго: Магистрант, докторантууд өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, арга туршлагаа харилцан солилцох боломжийг олгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйд суралцахад оршино.

Илтгэл хүлээн авах хугацаа:

- Илтгэлийг цахимаар 2023 оны 03 дугаар сарын 03-аас 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд хүлээн авна.

Цахимаар хүлээж авах E-mail: Магистрантууд: ch.boldbaatar.63@gmail.com 88286325

Хамрах хүрээ: Магистрант, докторантууд

Хугацаа: "Эрдэм судлал 2023" магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний бага хурал 2023 оны 3 дугаар сарын 21-нд Сүбээдэй танхимд болно.

Илтгэлд тавигдах шаардлага: ҮБХИС-ийн стандартын дагуу бичнэ.

- Илтгэл нь эрдэм шинжилгээний ажлын удирдагч, эсвэл тухайн мэргэжлийн чиглэлийн эрдэмтнээр хянан баталгаажуулсан байна;

- Өгүүллийн нэр; /12pt өндөртэй үсгээр, мөр хоорондын зай 1 байхаар, тод (Bold), том (Caps Lock) үсгээр голлуулсан бичнэ./

- Зохиогчийн овог, нэр; (12pt өндөртэй үсгээр, налуу (Italic) форматаар мөр голлон бичнэ.

- Хураангуй; /15 мөр, 150-250 үгэнд багтааж бичнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ./

- Түлхүүр үг; /3-5 түлхүүр үг хэрэглэнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ.

- Судалгааны ажлын үндсэн хэсэг /Өгүүллийг Arial фондоор, мөр хоорондын зай 1,15 байхаар, А4 хэмжээний цаасан дээр зүүн гар талаас 30 мм, баруун гар талаас 15 мм, дээд, доод талаас 20 мм-ийн зай авч бичнэ. Өгүүллийг 10 хүртэлх хуудсанд багтаан бичнэ./

- Дүгнэлт.

- Өгүүлэлд ашигласан эх сурвалжаас заавал эш татна. Эш татсан эх сурвалжийг бичвэрийн холбогдох хэсэгт зүүлт эшлэлийн аргаар (insert footnote) хуудасны доод хэсэгт оруулна. Эшлэлийн эх сурвалжид зохиогч, эх сурвалжийн нэр, хэвлэгдсэн улс, хот, хэвлэгдсэн он, хэвлэгдсэн газар, хэмжээ (хуудасны тоо), хуудасны дугаар/тал, ISBN-ын дугаар зэргийг дэс дараалуулан бичнэ.

ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛЬ

МӨРДЭСТНҮҮДИЙН "ХОББИ" ҮЗЭСГЭЛЭН ҮЗЭГЧДИЙН ХҮРТЭЭЛ БОЛЛОО



Монгол Улсад "Хурандаа" цол бий болж, хүртээж эхэлсний 87 жилийн ой, "Монгол хурандаагийн өдөр"-т зориулсан хүндэтгэлийн өдөрлөгийн арга хэмжээнд оролцогч мөрдэст цуглуулагчдын төлөөллүүд "ХОББИ" үзэсгэлэнг дэглэн баярын өдрөөрөө үзэгчдийн хүртээл болголоо.

Тус үзэсгэлэнд оролцогч мөрдэстэй цуглуулагчид өөрсдийн ховор сонин, нандин, бэлгэдэлт

цуглуулгуудаа хүндэт зочдоод сонирхуулан хууч яриа дэлгэсний зэрэгцээ МУСГЗ, хурандаа Г.Золзаяа даргатай Байлдааны гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын үе үеийн уран бүтээлчдийн төлөөллүүд урлагийн мэндчилгээ дэвшүүлж сайн сайхны ерөөл өргөсөн юм.

ЦДБЭЧ



Насан туршийн нөхөрлөл
Нэгэн насны андүүд

